

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

**Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.**

1. Дараах бодомжуудаас аль нь зөв бэ? /1 оноо/
 A. Нийгэм бол хүмүүсийн хамтын амьдрал, харилцаа холбооны систем мөн
 B. Нийгэм бол төрийн харилцаа C. Нийгэм бол угсаатны харилцаа
 D. Нийгэм бол хүмүүсийн соёлын харилцаа E. Нийгэм бол хүний амьдрах орчин
2. Энгийн нийгмийн ялгагдах шинжид аль нь хамааралгүй вэ? /1 оноо/
 A. Овог төрлийн холбоо B. Нийгмийн овгийн зохион байгуулалт
 C. Эд хөрөнгийн ялгаагүй байдал D. Анги давхраа, төр үүссэн
 E. 50000-40000 жилийн өмнө үүссэн
3. Хүмүүс бие биетэйгээ харилцан үйлчлэх үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 A. Нийгмийн харилцаа B. Нийгмийн харилцан үйлдэл C. Нийгмийн үйл ажиллагаа
 D. Нийгмийн зан заншил E. Нийгмийн хууль
4. Нийгмийн харилцааг эртний үед ямар арга хэрэгслээр зохицуулдаг байсан бэ? /1 оноо/
 A. Ёс заншил B. Эрх зүй C. Хууль D. Зарлиг E. Тогтоол шийдвэр
5. Нийгмийн улс төрийн хүрээний харилцаанд аль нь хамааралтай вэ? /1 оноо/
 A. Хуваарилалтын харилцаа B. Гэр бүлийн харилцаа
 C. Ашиг сонирхлоо хэрэгжүүлэх төрийн засаглалтай харилцах харилцаа
 D. Нийгмийн халамжийн харилцаа E. Соёлын харилцаа
6. Хууль эрхийн хэм хэмжээгээр нийгмийн харилцааг зохицуулах нь аль хүрээний асуудал вэ? /1 оноо/
 A. Улс төр B. Соёл-оюуны C. Социал D. Эрх зүйн E. Эдийн засаг
7. Доржийн охин МУИС-д элсэв. Энэ нь нийгмийн харилцааны аль түвшний илрэл вэ? /2 оноо/
 A. Хувь хүмүүс хоорондын B. Бүлэг хоорондын C. Байгууллага хоорондын
 D. Иргэн ба байгууллага хоорондын E. Гэр бүл хоорондын
8. Долгор халамжийн тэтгэвэр авдаг нь нийгмийн аль хүрээний харилцаанд хамаарагдах вэ? /1 оноо/
 A. Эдийн засаг B. Социал C. Улс төр D. Оюуны E. Хүмүүнлэг
9. Хүний нийгэмшлийн хамгийн гол орчин аль нь вэ? /1 оноо/
 A. Байгаль B. Соёл C. Нийгэм D. Газарзүйн орчин E. Найз нөхөд
10. Дараах нийгмийн хэв маягийн алинд нь нийгмийн тэгш биш байдал илүү хэлбэржсэн бэ? /2 оноо/
 A. Агнуурын нийгэм B. Түүвэрлэгчдийн нийгэм C. Аж үйлдвэржсэн нийгэм
 D. Газар тариалангийн нийгэм E. Цэцэрлэгийн аж ахуйн буюу энгийн тариалангийн нийгэм
11. Нийгмийн хэв маягуудтай шууд хамаарагдах харилцаануудад буруу холбоос орсон болаль вэ? /3 оноо/
 A. Агнуурын нийгэм – Технологи – Шинжлэх ухаан өндөр хөгжсөн
 B. Энгийн тариалангийн нийгэм – Суурьшил – Үржил шимтэй газар сэлгэн нүүдэг
 C. Аж үйлдвэржсэн нийгэм – Эдийн засаг – Илүүдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгддэг
 D. Газар тариалангийн нийгэм – Тэгш биш байдал – Хүн амын олонх нь ядуу тариачид
 E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм – Нийгмийн байгууллагууд – Институтууд
12. “Коммунист нийгэм” хэмээх ойлголт нийгмийн хөгжлийн онолын аль хандлагад хамаарах вэ? /1 оноо/
 A. Иргэншлийн онол B. Эдийн засгийн өсөлтийн үе шатуудын онол
 C. Нийгэм эдийн засгийн формацийн онол D. Бүтэц үүргийн онол
 E. Морганы нийгмийн хөгжлийг ангилсан үзэл санаа

13. Нэн эрт үед ямар нийгмийн хэв маяг зонхилж байсан бэ? /1 оноо/
 А. Аж үйлдвэржсэн В. Уламжлалт С. Газар тариалангийн
 D. Аж үйдвэржсэний дараах E. Цэцэрлэгийн аж ахуйн
14. "Улс төр бол нийгмийн үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах үйл байдал" гэж хэн тодорхойлсон бэ? /1 оноо/
 А. Ф.Бро В. Г.Лассуэл С. Д. Истон D. М. Вебер E. К. Маркс
15. Аливаа засаглалын харилцаа, үйл ажиллагааны зөвхөн төрийн эрх мэдэлтэйхолбогдох тэр хэсгийг.....гэнэ. /1 оноо/
 А. Төр В. Хууль С. Соёл D. Улс төр E. Уламжлал
16. Засаглалын бүтцийн гол бүрдлүүдэд хамаарагдахгүй зүйл аль нь вэ? /2 оноо/
 А. Засаглалын субъект В. Засаглалын нөөц С. Засаглалын объект
 D. Засаглалын механизм E. Засаглалын легитим чанар
17. Засаглалын нөөцийг ангилахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
 А. Эдийн засгийн В. Нийгмийн /социал/ С. Хүн амын
 D. Соёл мэдээллийн E. Цаг хугацааны
18. Улс төрийн засаглалын онцлог шинжийг тэмдэглэнэ үү /2 оноо/
 А. Сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрөгдсөн улс төр, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээнүүдээр зохицуулагддаг засаглал
 B. Хууль цаазын үндэстэй албадлага хэрэглэх C. Шийдвэр гаргах онцгой эрх эдэлдэг
 D. Хүн амыг нийтэд нь хамардаг E. Улс орны нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамардаг
19. Уламжлалт легитим шинжийн эх сурвалж юунд суурилдаг вэ? /1 оноо/
 А. Удирдагчийн онцгой авьяас чадвар В. Хууль эрх зүй С. Нэр хүнд
 D. Ёс заншил E. Илтгэх чадвар
20. Наймаалцах эрх мэдлийн онцлогыг тэмдэглэнэ үү /1 оноо/
 А. Төр иргэн хоёрын гэрээ хэлцэл В. Айдас С. Дайчлах
 D. Үймээн самуун E. Зүтгэх хүсэл
21. Улс төрийн системийн элементэд аль нь хамааралгүй вэ? /1 оноо/
 А. Төр В. Сонирхлын бүлэг С. Иргэд D. Улс төрийн нам E. Шашин
22. 2008 оны 7-р сарын 1-ний үйл явдал улс төрийн системийн аль сувагт хамаарагдахвэ?/2 оноо/
 А. Оролт В. Хувиралт С. Гаралт D. Эргэх холбоо E. Орчин
23. Иргэд сонгуульд саналаа өгөх нь улс төрийн оролцооны ямар хэлбэр вэ? /1 оноо/
 А. Нийцгүй оролцоо В. Нийцтэй оролцоо С. Урсгал оролцоо
 D. Лидерийн оролцоо E. Нөлөөлөх оролцоо
24. Төрийн бус байгууллагуудын зорилгыг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?/1 оноо/
 А. Гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах В. Хувийн ашгийн төлөө бус
 C. Сайн дурын үндсэн дээр иргэд эвлэлдэн нэгдэх D. Засгийн эрхийн төлөө эрмэлзэх
 E. Өөрийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаа явуулах
25. Сонирхлын бүлгийг ангилахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
 А. Аномик В. Эвлэл холбооны бус С. Байгуулагжсан
 D. Намын бүлэг E. Эвлэл холбооны
26. Улс төрийн намын онцлог шинжүүдэд хамааралгүй зүйл аль вэ? /1 оноо/
 А. Төрийн хэмжээнд засаглалыг авах, хөтөлбөрөө хэрэгжүүлэх
 B. Удирдах болон орон нутгийн байгууллагыг багтаасан зохион байгуулалтын бүтэцтэй
 C. Төрийн засаглалыг авахын тулд сонгогчдоор дэмжүүлэх эрмэлзэлтэй
 D. Аль нэгэн үзэл суртлыг үйл ажиллагааныхаа удирдлага болгох
 E. Бие даасан, бүрэн эрхт шинжтэй

27. Ганц хүн нэгэн биеийн тусыг бодон өөрийн засгийг олонхид тулган зоргоор авирлах засаглалыг Аристотель ямар засаглал гэж нэрлэсэн бэ? /1 оноо/

- A. Монархи В. Аристократи С. Тирани D. Полити E. Олигархи

28. Олон ургальч ардчиллын үзэл санааны зарчмуудад аль нь хамааралгүй вэ? /2 оноо/

- A. Нийгмийн доторх санаа бодлын илэрхийлэл болсон улс төрийн нам, бүлгүүдийн үүргийг чухалчилдаг
 B. Төр засаг нь ард түмнийхээ өмнө биш, харин нам, бүлгийн өмнө хариуцлага хүлээдэг
 C. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд нам, бүлгүүдийг тэгш оролцуулан зөвшилцлөөр нийгмийн нэгдмэл байдлыг хангах
 D. Элит нь улс орныг захирдаг аль нэг талаараа шалгарсан давуу талтай хүмүүсээс бүрдэж ерийн олон түмнээс ялгардаг
 E. Шийдвэр гаргахад бүх хүнийг оролцуулах боломжгүй ч ардчиллын зарчмуудыг бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой

29. Өмчийн хэв маягуудыг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль вэ? /1 оноо/

- A. Нийтийн өмч В. Хувийн өмч С. Холимог өмч D. Төрийн өмч E. Оюуны өмч

30. Худалдан авах чадвараар баталгаажсан хэрэгцээг юугэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Хэрэгцээ В. Нийлүүлэлт С. Хүний хүсэл D. Эрэлт E. Шаардлага

31. Энгийн барааны хувьд тухайн барааг орлуулах барааны үнэ буурвал: /2 оноо/

- A. Эрэлт нь нэмэгдэж, үнэ нь өснө В. Нийлүүлэлт нь нэмэгдэж үнэ нь өснө
 C. Эрэлт нь буурч, үнэ нь өснө D. Нийлүүлэлт нь буурч, үнэ нь буурна
 E. Эрэлт нь буурч, үнэ нь буурна

32. Төгс өрсөлдөөний зах зээлийн онцлогуудыг олж тэмдэглэнэ үү. /3 оноо/

- a. Зах зээлийн үнэд борлуулагч, худалдан авагч аль аль нь нөлөө үзүүлж чадахгүй
 в. Зах зээлд орж гарах нь бүрэн чөлөөтэй с. Монополь үнэ тогтоох
 d. Мэдээлэл нээлттэй, ил тод байх e. Борлуулагчид өөр хоорондоо үгсэн нийлэх
 A. a, a, в В. в, с, a С. a, в, dD. c, в, a E. e, c, a

33. Ажилгүйдлийн үндсэн хэлбэрүүдийг холбогдох нөхцлүүдтэй нь зөв тохируулна уу? /3 оноо/

а	Завсрын ажилгүйдэл	1	Эдийн засгийн уналт, зогсолт, сэргэлт, тогтворжилтийн мөчлөгт стратегийн зарим бүтээгдэхүүний үнэ ханш, инфляцийн өгсөх уруудах хөдөлгөөнтэй холбогдон үүсдэг ажилгүйдэл
в	Бүтцийн ажилгүйдэл	2	Нэг ажлаас нөгөө ажилд шилжихэд хүлээхтэй холбоотой, түр зуурын ажилгүйдэл
с	Мөчлөгийн ажилгүйдэл	3	Нийгэм эдийн засагт өөрчлөлт гарч буйтай холбогдон мэргэжил, ур чадвар шаардсан ажиллах хүчний эрэлт өсч, нөгөө заримынх нь буурч байгаатай холбоотойгоор үүсдэг ажилгүйдэл

- A. a1, в3, с2 В. a2, в1, с3 C. a2, в3, с1 D. a1, в2, с3 E. a3, в2, с1

34. Ажил эрхлэлтийн түвшинг ямар үзүүлэлтээр хэмждэг вэ? /2 оноо/

- A. Мэргэжлийн ур чадвар дутмагаас
 B. Ажиллах хүчний нөөцийн хомсдолоос
 C. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхэлж байгаагаар
 D. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхлэхгүй байгаагаар
 E. Хөдөлмөрийн нийлүүлэлт ба хөдөлмөрийн эрэлтийн харьцаа алдагдсанаас

35. Улсын төсөв гэж юу вэ? /1 оноо/

- A. Мөнгөн хөрөнгийн санг бүрдүүлэх, түүнийг зарцуулах төв банкны төлөвлөгөө
 B. Орлогын эх үүсвэрийн төлөвлөгөө
 C. Мөнгөн хөрөнгийн санг бүрдүүлэх, түүнийг зарцуулах засгийн газрын санхүүгийн төлөвлөгөө
 D. Төлбөрийн тайлан тооцоо
 E. Орон нутгийн төсвийн төлөвлөгөө

36. Иргэд улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн төлөөсийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 А. Орлого В. Өмч хөрөнгө С. Ашиг D. Албан татвар E. Зарлага
37. Мөнгөний хэлбэрүүдийн дотроос хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэлбэрийг нэрлэнэ үү. /1 оноо/
 А. Металл зоос В. Цаасан мөнгө С. Зээлийн мөнгө
 D. Цахим мөнгө E. Таваарын мөнгө
38. Төв банкны үндсэн үүрэгт аль нь хамаарагдахгүй вэ? /2 оноо/
 А. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах
 B. Арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих
 C. Зах зээлийн харилцааг зохицуулах
 D. Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулан мөнгөний бодлого хэрэгжүүлэх
 E. Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах
39. Хэрвээ ҮНБ-үндэсний нийт бүтээгдэхүүн, ДНБ- дотоодын нийт бүтээгдэхүүн, ҮЦБ-үндэсний цэвэр бүтээгдэхүүн, ҮО- үндэсний орлого, ШБТ- шууд бус татвар бол үндэсний орлогын томъёог ол.
 А. $ҮО = ҮНБ - ДНБ$ В. $ҮО = ДНБ + ШБТ$ С. $ҮО = ҮЦБ - ШБТ$ /2 оноо/
 D. $ҮО = ҮЦБ + ШБТ$ E. $ҮО = ДНБ + ҮЦБ$
40. Инфляци гэж юу вэ? /1 оноо/
 А. Эргэлтэнд байгаа мөнгөний хэмжээ гүйлгээнд байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээтэй шууд пропорционал хамааралтай байх
 B. Үнийн түвшний өсөлт хоёр оронтой тоонд хүрэх
 C. Үйлдвэрлэлийн тодорхойсалбарын бүтээгдэхүүний суурь үнэ өсөх
 D. Үнийн өсөлт, мөнгөний худалдан авах чадвар буурах
 E. Цалинг үндэслэлгүй өсгөх
41. Далд эдийн засгийг үүсгэдэг гол шалтгааныг олж тэмдэглэнэ үү /2 оноо/
 А. Үйлдвэрлэлийн өсөлтөөс В. Үнийн өсөлтөөс С. Хэт өндөр татвар тогтоосноос
 D. Мөнгөний үнэгүйдлээс E. Бараа бүтээгдэхүүний хомсдлоос
42. 1990 оноос өмнөх үеийн Монголын анги давхрааны бүтцийн зөв загварыг олно уу? /1 оноо/
 А. Дарга, ажилчин, малчин В. Дээд анги, дунд анги, доод анги
 C. Бизнесмен, Ажилчин, малчин D. Ажилчин, малчин, сэхээтэн
 E. Малчин, албан хаагч, сэхээтэн
43. Монгол улсын нийгмийн хамгааллын тогтолцоо ямар бүрдэлтэй вэ? /1 оноо/
 А. Татвар ба хураамж В. Улсын ба орон нутгийн төсөв
 C. Нийгмийн даатгал ба нийгмийн халамж D. Банк ба санхүү
 E. Бодит орлого ба зарлага
44. Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр нь нийгмийн даатгалынямар санд хамаарагдах вэ? /1 оноо/
 А. Тэтгэврийн даатгалын сан B. Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан
 C. Тэтгэмжийн даатгалын сан D. Ажилгүйдлийн даатгалын сан E. Эрүүл мэндийн даатгалын сан
45. Малчны хүү Бат-Эрдэнэ цэргийн алба хааж, дархан аварга болж, УИХ-ын гишүүнээр гурвантаа сонгогдож улмаар ерөнхийлөгчид нэр дэвшиж байна. Энэ нь нийгмийн шилжих хөдөлгөөний ямар төрлийн жишээ вэ? /2 оноо/
 А. Үе доторх В. Нутаг дэвсгэрийн C. Үе хоорондын D. Гэр бүлийн E. Бүтцийн
46. Нийгмийн халамжийн арга хэмжээнд хэн хамрагдахгүй вэ? /1 оноо/
 А. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
 B. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд
 C. Ядуу, нэн ядуу амьдралтай дөрвөөс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх [эцэг]
 D. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид
 E. Тэжээн тэтгэх төрөл садангүй, бие даан амьдрах чадваргүй ахмад настан

47. Хүүхэд асарсны тэтгэмж нь халамжийн үйлчилгээний ямар төрөлд хамаарагдах вэ? /2 оноо/
 А. Халамжийн тэтгэвэр В. Халамжийн тэтгэмж С. Улсын төсвөөс олгосон тэтгэмж
 D. Улсын төсвөөс олгосон тусламж E. Нийгмийн халамжийн үйлчилгээ
48. Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст аль нь хамааралтай вэ? /1 оноо/
 А. Төрийн албан хаагч В. Хувиараа хөдөлмөр эрхлэгч
 C. Хөгжлийн бэрхшээлтэй хүн D. Малчид E. Компаний эзэд
49. Нийгмийн гишүүдийн олонх нь дагадаг үнэлэмж, итгэл үнэмшил, уламжлал зан заншлыг.....гэнэ.
 Зөв өгөгдлийг нөхнө үү /1 оноо/
 А. Дагуул соёл В. Элитийн соёл C. Сөрөг соёл D. Зонхилох соёл E. Ардын соёл
50. Монголчууд эрт үеэс үр хүүхдээ бага балчраас нь юу зөв, юу буруу, юу буян, юу нүгэл болохыг
 зааж сургаж биеэр үлгэрлэж ирсэн. Энэ нь соёлын хэм хэмжээний альангилалд хамаарах вэ?
 /2 оноо/
 А. Албан хэм хэмжээ В. Албан бус хэм хэмжээ C. Тогтоол D. Зарлиг E. Шийдвэр
51. Сүүлийн үед манай залуучуудын зарим хэсгийн дотор эд хөрөнгийг шүтэх,хөдөлмөрийн бус
 аргаар баяжиж тансаглан чамирхах сэтгэл зүй нилээдгүй газар авчээ.Энэ байдал соёлын ямар
 бүрэлдэхүүн хэсэгт хамаарагдах вэ? /2 оноо/
 А. Хэм хэмжээ В. Итгэл үнэмшил C. Үнэлэмж D. Мэдлэг E. Ёс заншил
52. Даяаршиж байгаа дэлхий ертөнцөд соёлын шинэчлэл, зээлдлэг, солилцоо үндэснийхүрээнээс
 хальж байгааг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 А. Үндэсний соёл В. Элитийн соёл C. Ардын соёл
 D. Олон улсын соёл E. Сөрөг соёл
53. “Өсөхөөс сурсан үндэсний хэл, мартаж болшгүй соёл” хэмээх их Нацагдоржийн үзэл санаа соёлын
 ямар чанарт хамаарагдах вэ? /2 оноо/
 А. Нийтлэг чанар В. Үнэлэмжийн чанар C. Залгамж чанар
 D. Бодит чанар E. Иргэнлэг чанар
54. Монгол улс гадаад харилцаандаа өөрийн стратегийн зорилтыг шат дараатай хэрэгжүүлэхэд ач
 холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд
 чиглэсэн байх шаардлага манай гадаад бодлогын ямар зарчмын үндэс вэ? /1
 оноо/
 А. Олон тулгуурт байх В. Идэвхтэй байх C. Тэнцвэртэй байх
 D. Үндэсний эрх ашигт нийцсэн байх E. Эрх тэгш байх
55. Социализмын үед Монгол улсын гадаад харилцаа нэг талын, хязгаарлагдмал шинжтэй байсан
 бодит нөхцөл шалтгаануудад аль нь тохирохгүй вэ? /2 оноо/
 А. Социалист хамтын нөхөрлөлийн байр суурь, эв нэгдлийн зарчимд захирагдсан
 В. Социализмын эрх ашгийг өмгөөлөн хамгаалах үзэл сурталд захирагдсан
 C. Дэлхийн улс төрийн бодлого үндсэндээ хоёр туйлтай болсон байсан
 D. Дэлхийн улсуудтай нээлттэй, олон тулгуурт зарчмын үндсэн дээр харилцан, хамтын
 ажиллагааг хөгжүүлэх зорилго
 E. Цэрэг-улс төрийн салбарт сөргөлцөх хандлага давамгайлж байсан
56. Монгол улсын Зүүн хойд Азийн /ЗХА/ улс орнуудтай харилцан ойлголцож, хамтран ажиллах
 гадаад харилцааны онцлог, нөхцлүүдэд аль нь тохирохгүй вэ? /2 оноо/
 А. Бараг бүх улс гүрнүүд нь өндөр хөгжилтэй, бие биетэйгээ хиллэн оршдог, өөрийн үл
 давтагдах онцлогтой бүс нутаг
 В. Монголын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын ихэнх хувийг ЗХА-ийн орнууд эзэлдэг
 C. Монгол улсын олон улсын нэр хүнд, байр суурийг олон улсын тавцан дээр бэхжүүлэхэд ЗХА-ийн
 улсуудын дэмжлэг нөлөө их ач холбогдолтой
 D. Гадаад харилцааны бодлогын хаалттай зарчим, үйл ажиллагаа
 E. Эдгээр улстай харилцан ойлголцож, хамтран ажиллаж туршлагаас нь суралцаж улс орноо
 хөгжүүлэх бодлого Монгол улсын гадаад харилцааны нээлттэй байх зарчимд нийцнэ

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР**Санамж: 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож хариуг бөглөөрэй.****2.Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.****2.1. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?****/5 оноо/**

a	Эдийн засгийн амьдралд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг	1	Төр татвар, улсын худалдаа зэргээр дамжуулан нөөцийн хуваарилалтанд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг
b	Нөөцийг хуваарилах үүрэг	2	Орлогыг дахин хуваарилах замаар нийгмийн амьжиргааны доод түвшинг баталгаажуулах, зохицуулалтын үйл ажиллагаа явуулдаг
c	Төгс өрсөлдөөн өрнөх нөхцлийг бүрдүүлэх үүрэг	3	Төр шаардлагатай хууль эрхийн актуудыг боловсруулан гаргаж, түүнийгээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаа явуулдаг
d	Орлогыг дахин хуваарилах үүрэг	4	Монополийг хязгаарласан, төгс өрсөлдөөн өрнөх таатай нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа явуулдаг
e	Эдийн засгийг тогтворжуулах үүрэг	5	Эдийн засгийн мөчлөгийн өрнөлт уналтыг хянаж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд санхүүгийн болон татварын бодлогыг ухаалаг ашиглах замаар үйлдвэрлэл ажил эрхлэлт, мөнгөний ханш бууралтын түвшинг хянах, зохицуулах үйл ажиллагаа явуулдаг

2.2. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?**/5 оноо/**

a	Шашны онол	1	Төр нь ард түмэн засаглалын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр бий болсон
b	Гэрээний онол	2	Хүмүүс ганц нэгээрээ биш харин нэгдэж, гаршсан зүйлээ дагнан эрхлэх замаар хэрэгцээгээ илүү ханган хөдөлмөрийн хуваарь тогтсон нь төрийн үүслийн шалтгаан болсон
c	Нийгэм эдийн засгийн онол	3	Төрийн засаглалын эх сурвалжыг бурханы зарлиг, элчийн үйл ажиллагааны бодит биелэл гэж үздэг
d	Ангийн онол	4	Төр бол хүчтэй хүмүүсээс нийгэмд дарангуйллаа тогтоох байгууллага бөгөөд эрх зүй бол хүчтэй нь хүчгүйдээ ашиг сонирхлоо тулган хүлээлгэх арга хэрэгсэл
e	Хүчирхийлэлийн онол	5	Нийгмийн хөдөлмөрийн хуваарь нэмүү бүтээгдэхүүн, хувийн өмч бий болсноор нийгэм ашиг сонирхлын хувьд эвлэршгүй ангиудад хуваагдаж нэг анги бусад ангийг дарангуйлах замаар төр үүссэн

2.3. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?**/5 оноо/**

a	Бэлгэ тэмдэг	1	Нийгмийн зүгээс хайрлан хүндлэгдэж, хамгаалагдсан үйлдлийн томоохон загвар
b	Үнэлэмж	2	Тодорхой хэмжээгээр хамтын мэдрэмж төрүүлдэг хэвшмэл болон бэлгэдлийн шинжтэй үйлдлүүдийн цогц
c	Хэм хэмжээ	3	Юуг сайн, хүсүүштэй хийгээд зохистой, юуг муу, хүсүүшгүй бөгөөд зохисгүй гэж үзэх талаарх хамтын ойлголтууд
d	Зан үйл	4	Ямарч үед байнга дагаж мөрдөж байх үйл, төрх байдлын ерөнхий дүрэм
e	Ёс заншил	5	Нийгмийн гишүүд нийтээр хүлээн зөвшөөрөн нэг объект, үйлдлээр нөгөөгийн утга учрыг илтгэх, илэрхийлэх үйлдэл, объект

2.4. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Ерөнхий ассамблей	1	Олон улсын энх тайван , аюулгүй байдлыг сахин хамгаалж бэхжүүлэх, улс хоорондын маргаантай асуудлыг шударгаар шийдвэрлэх үүрэг бүхий байгууллага
b	Аюулгүйн зөвлөл	2	НҮБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг болон бичиг хэргийг гардан хариуцдаг байгууллага
c	Олон улсын шүүх	3	Салбар байгууллагуудын эдийн засаг нийгмийн талын үйл ажиллагааг зохицуулан чиглүүлэх байгууллага
d	Нарийн бичгийн дарга нарын газар	4	Улс орнуудын хоорондын эрхзүйн маргаантай асуудлыг шийдэх, хуулийн зөвлөгөө өгдөг байгууллага
e	Эдийн засаг нийгмийн зөвлөл	5	НҮБ-ын бүх гишүүн орны төлөөлөгчдөөс бүрддэг дэлхийн эдийн засаг, нийгмийн болон бусад салбарт олон улсын харилцаанд тус дөхөм үзүүлдэг байгууллага

